

АГУУЛГА

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн товч тодорхойлолт.....	3
1.2. Төслийн байршил.....	4
1.3. Ордын геологийн нөөц	5
1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц	5
1.5. Уурхайн хүчин чадал, ажиллах горим.....	5
1.6. Уурхайн талбайд ашиглалт явуулах дараалал	6
1.7. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн иж бүрдэл.....	6
1.8. Үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим	7
1.9. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн иж бүрдэл.....	8
БҮЛЭГ-2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	9
БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	10
3.1. Агаарын чанарт нөлөөлөх байдал	10
3.2. Газрын гадарга, хэвлэлийд нөлөөлөх байдал	10
3.3. Усны чанарт нөлөөлөх байдал	10
3.4. Хөрсний чанарт нөлөөлөх байдал	10
3.5. Ургамалан нөмрөгт нөлөөлөх байдал	10
3.6. Амьтны аймагт нөлөөлөх байдал.....	11
3.7. Төслийн болзошгүй сөрөг нөлөөллүүд	11
БҮЛЭГ-4. “НОГООН ТОЛГОЙ-1” ТООСГОНЫ ШАВРЫН УУРХАЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	13
4.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	13
4.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
4.3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	18
4.4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө...20	20
4.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	21
4.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
4.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	22
4.8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	25
4.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26
4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	28
4.11. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлagnaх төлөвлөгөө	30
4.12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгтгэл.....	31
ДҮГНЭЛТ	32
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	33

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн товч тодорхойлолт, үндсэн үзүүлэлтүүд.....	3
Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол	4
Хүснэгт 3 “Ногоон толгой-1” тоосгоны шаврын ордын батлагдсан геологийн нөөц	5
Хүснэгт 4. “Ногоон толгой-1” тоосгоны шаврын ордын үйлдвэрлэлийн нөөц	5
Хүснэгт 5. Уурхайн ажиллах горим, хүчин чадал	6
Хүснэгт 6. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд.....	6
Хүснэгт 7. Тоосго үйлдвэрлэлийн хүчин чадал төлөвлөлт	7
Хүснэгт 8. Тоосгоны үйлдвэрлийн ажиллах горим, хүчин чадал	7
Хүснэгт 9. Тоосго үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмжүүд.....	8
Хүснэгт 10. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөлийн төрөлтэй уялдах нь	11
Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
Хүснэгт 12. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	19
Хүснэгт 13. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	23
Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	25
Хүснэгт 15. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг	4
Зураг 2. Тоосго үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн дамжлага схем	8

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч тодорхойлолт

Хүснэгт 1. Төслийн товч тодорхойлолт, үндсэн үзүүлэлтүүд

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	УТГА
1	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	“ТӨГС-ЭРХЭС” ХХК
2	Төсөл хэрэгжүүлэгчийн улсын бүртгэлийн мэдээлэл	Улсын бүртгэлийн дугаар: 9011137056 Бүртгэгдсэн огноо: 2008.02.19 Регистрийн дугаар: 5200288
3	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо, Ногоон толгой-1
4	Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын мэдээлэл	Захирал: Г.Ганхуяг Утас: 9905-2599
5	Төслийн нэр	Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Ногоон толгой-1” тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглах, тоосго үйлдвэрлэх төсөл
6	Төслийн байршил	Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо
7	Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-013499
8	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Олгосон огноо: 2008.04.08 Дуусах огноо: 2037.02.09
9	Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ	10.6 га
10	Ордын тоосгоны шаврын батлагдсан геологийн нөөц	291.15 мян.м³
11	Ордын тоосгоны шаврын үйлдвэрлэлийн нөөц	225.0 мян.м³
12	Шавар олборлолтын жилийн хүчин чадал	11.25 мян.м³
13	Тоосго үйлдвэрлэлийн жилийн хүчин чадал	4.0 сая ширхэг


1.2. Төслийн байршил

“Ногоон толгой-1” тоосгоны шаврын уурхай нь засаг захиргааны нэгжийн хувьд Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутагт хамаарах бөгөөд Улаанбаатар хотын төвөөс 40 км зайд, Монгол улсын 1:100000-ны масштабтай байр зүйн зургийн L-48-11 тоот хавтгайд оршино.

Үг орд байрлаж буй нийт 10.6 га талбай бүхий MV-013499 тоот түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцолыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол

№	Тусгай зөвшөөрлийн дугаар, талбайн нэр	Талбайн хэмжээ, га	Солбилцол	
			Өргөрөг	Уртраг
1	MV-013499 Ногоон толгой-1	10.6	47° 44' 35.77"	107° 18' 26.37"
2			47° 44' 35.77"	107° 18' 16.37"
3			47° 44' 42.77"	107° 18' 16.37"
4			47° 44' 42.77"	107° 18' 18.37"
5			47° 44' 54.77"	107° 18' 18.37"
6			47° 44' 54.77"	107° 18' 26.37"



Зураг 1. Төслийн талбайн байршилын зураг

1.3. ОРДЫН ГЕОЛОГИЙН НӨӨЦ

Геологийн тогтоцын шинж чанар, ашигт малтмалын нөөцийн хэмжээгээрээ “Ногоон толгой-1” тоосгоны шаврын орд нь ордын нөөцийн ангилалаар II зэргийн ордод хамаарах ба ашигт малтмалын зузаан ба чанар тогтвортой, хэмжээний хувьд дунд зэргийн ордод хамаарна. Нийт ордын хэмжээнд шаврын дундаж зузаан 3.62 м, нийт тоосгоны шаврын нөөц бодитой (B) зэрэглэлээр 291.15 мян.м³, хуулах хөрсний зузаан 0.2 м байна.

Хүснэгт 3 “Ногоон толгой-1” тоосгоны шаврын ордын батлагдсан геологийн нөөц

№	Нөөцийн блокийн дугаар ба нөөцийн	Блокийн талбай, м ²	Хуулах хөрсний дундаж зузаан, м	Ашигт малтмалын дундаж зузаан, м	Хуулах хөрсний эзэлхүүн, м ³	Ашигт малтмалын нөөц, м ³	Хөрс, шаврын харьцаа
1	B-1	33243.18	0.20	3.57	6648.77	118680.40	1:18
2	B-2	19201.91	0.20	3.50	3841.21	67206.6	1:17
3	B-3	27703.35	0.20	3.80	5540.67	105272.73	1:19
Нийт		80148.44	0.20	3.62	16030.65	291159.73	1:17

1.4. ОРДЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НӨӨЦ

“Ногоон толгой-1” тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглах үеийн үйлдвэрлэлийн нөөц нь 225.0 мян.м³ байхаар ТЭЗҮ-д тооцож тусгасан байна.

Хүснэгт 4. “Ногоон толгой-1” тоосгоны шаврын ордын үйлдвэрлэлийн нөөц

Блокийн дугаар	Уурхайн хилээр блокийн хөрс хуулах талбай, м ²	Хөрсний зузаан, м	Хөрсний эзлэхүүн, м ³	Олборлогдох геологийн нөөц, м ³	Ашиглалтын хаягдал		Бохирдолт	Магадлагдсан үйлдвэрлэлийн нөөц, м ³
					%	Шавар, м ³		
B-1	23923.5	0.3	7177.1	81930	4.11	3367	0.952	748
B-2	17784.0	0.3	5335.2	59130	4.11	2430	0.952	539
B-3	25129.0	0.3	7538.7	91371	4.11	3755	0.952	834
Нийт	66836.5	0.3	20051.0	232431	4.11	9552	0.952	2121
							Зэрэг	Шавар, м³
								225000

1.5. УУРХАЙН ХҮЧИН ЧАДАЛ, АЖИЛЛАХ ГОРИМ

Уурхайн хүчин чадал: Уурхайн хүчин чадлыг техник-эдийн засгийн үндэслэлд жилд 11.25 мян.м³ тоосгоны шавар олборлон боловсруулахаар тооцож тусгасан байна.

Уурхайн ажиллах горим: “Ногоон толгой-1” тоосгоны шаврын уурхай нь улирлын чанартай ажиллах бөгөөд 5-р сарын 1-нээс 10-р сарын 1-нийг хүртэл жилд нийтдээ 5 сар ажиллана.

Хүснэгт 5. Уурхайн ажиллах горим, хүчин чадал

№	Горимын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга
1	Жилийн хуанлийн хоног	хоног	365
2	Өвлийн улирлын сул зогсолт	хоног	209
3	Жилийн ажиллах хуанлийн хоног	хоног	156
4	Баяр ёслолын амралт	хоног	7
5	Цаг агаарын саатал	хоног	5
6	Засвар үйлчилгээ	хоног	7
7	Олборлолтын ажлын хоног	хоног	153
8	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	1
9	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	8
10	Цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.8
11	Хоногт ажиллах бодит цаг	цаг	6.4
12	Жилд ажиллах бодит цаг	цаг	1224
13	Уурхайн цагийн хүчин чадал	м ³ /цаг	11.49
14	Уурхайн хоногийн хүчин чадал	м ³ /хоног	73.53
15	Уурхайн жилийн хүчин чадал	м ³ /жил	11250.0

1.6. УУРХАЙН ТАЛБАЙД АШИГЛАЛТ ЯВУУЛАХ ДАРААЛАЛ

“Ногоон толгой-1” нэртэй тоосгоны шаврын ордод ашиглалт явуулах үйл ажиллагаа нь дараах дарааллын дагуу явагддаг.

Шавар олборлолт: ШИМТ ХӨРС ХУУЛАЛТ ► ТООСГОНЫ ШАВАР ОЛБОРЛОЛТ

Тоосго үйлдвэрлэл: ТООСГО ҮЙЛДВЭРЛЭХ ► ХАТААХ ► ШАТААХ ► БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭГЧДЭД НИЙЛҮҮЛЭХ.

Үүний зэрэгцээ уурхайн тээврийн замыг цэвэрлэх, хуурайшилт ихтэй үед тоосжилтыг бууруулах мөн тоног төхөөрөмжид засвар, үзлэг үйлчилгээ хийх гэх мэт туслах ажлууд хийгдэнэ.

1.7. УУРХАЙН ҮНДСЭН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ИЖ БҮРДЭЛ

Уурхайд олборлолтын үйл ажиллагаа явуулахаас өмнө үржил шимт хөрсний үеийг утгуурт ачигчаар хусаж бөөгнүүлэн автосамосвалд ачиж тээвэрлэн тусгай овоолгод байршуулж стандартын дагуу хадгална.

Тухайн жилийн ашиглалтанд өртөх талбайн шимт хөрсийг хуулсаны дараа нээгдсэн шаврын үеийг экскаватораар сийрэгжүүлэн ухаж автосамосвалд ачин цааш үйлдвэрийн талбай руу тээвэрлэж тоосго үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн шавар хүлээн авах хэсэгт хүргэнэ.

Хүснэгт 6. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд

№	Техник	Марк	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	Экскаватор	Hyundai R210LC	1	0.92 м ³
2	Автосамосвал	Hyundai HD	2	15 тн
3	Утгуурт ачигч	YTO ZL30-II	1	1.4 м ³
-	Нийт	-	4	-

1.8. Үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим

“Ногоон толгой-1” тоосгоны шаврын уурхайн дэргэдэх тоосгоны үйлдвэр нь жилд дунджаар 4.0 сая ширхэг тоосго үйлдвэрлэх хүчин чадалтай.

Хүснэгт 7. Тоосго үйлдвэрлэлийн хүчин чадал төлөвлөлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Жилд
1	Үйлдвэрлэх тоосгоны хэмжээ	мян.ш	4122.45
2	Тоосгоны технологийн хаягдал, 2%	мян.ш	122.45
3	Борлуулах тоосго	мян.ш	4000

Тоосгоны үйлдвэр нь жилд дунджаар 4.1 сая ширхэг тоосго үйлдвэрлэх ба технологийн хаягдлыг хасаж тооцсоноор 4.0 сая ширхэг тоосгыг зах зээлд нийлүүлэх зорилт тавин ажилладаг.

Тоосго үйлдвэрлэх технологи:

Тоосго үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь ерөнхийдөө: ТҮҮХИЙ ЭД, МАТЕРИАЛЫГ БУТЛАХ, ШИГШИХ ► ТҮҮХИЙ ТООСГО ҮЙЛДВЭРЛЭХ ► ХАТААХ ► ШАТААЖ БОЛОВСРУУЛАХ ► ЭЦСИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭГЧДЭД НИЙЛҮҮЛЭХ гэсэн технологийн дарааллаар ажиллана.

Тоосго үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь уурхайн үйл ажиллагаатайгаа адил улирлын чанартай явагдах бөгөөд 3-р сарын 20-ноос сар гаран бэлтгэл ажил, 5-р сарын 1-нээс 10-р сарын 1-ныг хүртэл үндсэн тоосго үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдах бөгөөд жилд нийтдээ 5 сар ажиллах юм. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь хоногт 8 цагийн 1 ээлжээр жилд бодитоор 153 хоног, 1224.0 цаг ажиллана.

Хүснэгт 8. Тоосгоны үйлдвэрийн ажиллах горим, хүчин чадал

№	Горимын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга
1	Баяр ёслолын амралт	хоног	7
2	Цаг агаарын саатал	хоног	5
3	Засвар үйлчилгээ	хоног	7
4	Бэлтгэл ажил	хоног	3
5	Тоосго үйлдвэрлэх бодит хоног	хоног	153
6	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	1
7	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	8
8	Цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.8
9	Жилд ажиллах бодит цаг	цаг	1224
10	Үйлдвэрийн цагийн хүчин чадал	мян.ш/цаг	4.50
11	Үйлдвэрийн ээлжийн хүчин чадал	мян.ш/ээлж	35.00
12	Үйлдвэрийн хоногийн хүчин чадал	мян.ш/хоног	35.00
13	Үйлдвэрийн жилийн хүчин чадал	мян.ш/жил	4,000.0

Тоосгоны үйлдвэрийн хоногийн хүчин чадал дунджаар 35.00 мян.ш, цагийн хүчин чадал дунджаар 4.50 мян.ш байна.

1.9. Үйлдвэрийн үндсэн тооног төхөөрөмжийн иж бүрдэл

Тоосго үйлдвэрлэх үйл ажиллагаа нь түүхий эд, материалыг бутлан үйлдвэрлэлд бэлдэх, тоосго үйлдвэрлэх, хатаах, шатааж боловсруулах, эцсийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх гэсэн ерөнхий шат дараалалтай явагдана.

Хүснэгт 9. Тоосго үйлдвэрлэлийн үндсэн тооног төхөөрөмжүүд

№	Тооног төхөөрөмжүүд	Марк	Хүчин чадал	Тоо	Чадал, кВт
1	Утгуурт ачигч	YTO ZL30-II	1.4 м ³	1	-
2	Бункер, тэжээгүүр	XGD-80	53 м ³ /цаг	2	7.8
3	Булт бутлуур	SGP-60/50	10-25 м ³ /цаг	2	19.5
4	Дамарт бутлуур	GP600x500	20-30 м ³ /цаг	1	31
5	Нүүрсний булт бутлуур	SGP-70/50	0.8-1.5 м ³ /цаг	1	13.8
6	Хос голт зуурагч	SGQ-300	25-30 м ³ /цаг	1	21
7	Вакум хэвлэгч	JKY500-4.0	4-6 мян.ш/ц	1	45
8	Гулдмай таслагч	ZT	1.2 м/сек	1	4.8
9	Тоосго зүсэгч	ZQPQ	40 удаа/мин	1	4
10	Туузан дамжуулагч	SBM-650	1.0 м/сек	2	3
11	Туузан дамжуулагч	SBM-650	0.8 м/сек	4	3
20	Тоосго шатаах зуух	24 камертай	4000 ш/цаг	1	-
21	Тоос цуглуулах төхөөрөмж	CSD20 2HP	2300 м ³ /цаг	3	1.2
-	Нийт	-	-	32	176.50



Зураг 2. Тоосго үйлдвэрлэлийн тооног төхөөрөмжийн дамжлага схем

БҮЛЭГ-2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уул зүй: Уул зүйн хувьд ордын район нь Хэнтийн уулархаг мужийн баруун урд хэсэгт Налайхын хотгорт хамарагдана. Энэхүү хотгорын туйлын өндөржилт далайн түвшнээс дээш 1400-1420 м (ордын талбайн хэсэгт) байна. Орд байрлаж буй хотгор нь баруунаас зүүн тийш чиглэлтэй, гонзгойдуу хэлбэртэй, төв хэсэгтээ хонхордуу, төв, зүүн талдаа тэгшивтэр талархаг гадаргуу үүсгэсэн байдаг.

Усан сүлжээ: Усан сүлжээний хувьд ордын хойгуур Туул гол урсан өнгөрөх ба Туул голын усны зардал маш тогтвортгүй, зун борооны үед голын усны түвшингийн хоногийн хэлбэлзэл 50-60 см-ээр дээшилдэг байна. Туул голын усны урсгалын хурд 1.2 м/сек, голын усны өргөн 30-70 м, гүн нь 0.8-3.5 м, мөн уулнаас эх авсан жижиг гол горхиуд Туул голд цутгадаг. Ордын зүүн талаар Налайхын гол урсац ба голын хөндийд жижиг тойрмууд тохиолддог байна.

Цаг уур: Цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай. Улирлын болон хоногийн температур эрс хэлбэлзэлтэй, атмосфериин тунадасны хэлбэлзэл 120-220 мм бөгөөд жилийн дунджаар 200 мм хүрнэ. Анхны цас 9-р сарын 15-ны үеэр, сүүлчийн цас 5-р сарын 15-ны үеэр орох жишээтэй байдаг. Хамгийн халуун нь 7-р сард, хамгийн хүйтэн нь 1-р сард болдог. Хамгийн их хур тунадас унадаг улирал нь зун байна. Өвөл хөрс нь 3-5 м гүн хөлддөг. Цэвдэгшилт нилээд тархалттай бөгөөд газрын тогтоц, чулуулгийн литологийн бүтцээс хамаарч нам дор газар 1.5-2.0 м, өндөрлөг хэсэгт 3.5-5.0 м-т тохиолдоно. Ордын дүүрэг нь газар хөдлөлтийн VII-VIII бүсэд хамаарна.

Хүн ам зүй: Налайх тосгон нь 7 мянга гаруй өрхийн 26 мянга орчим хүн амтай бөгөөд Халх, Казак, Буриад, Урианхай, Дөрвөд зэрэг ястнуудаас бүрдэнэ.

Дэд бүтэц: Дэд бүтцийн хувьд орд нь сайн хөгжсөн бүсэд оршдог, Улаанбаатар хоттой асфальтан зам болон төмөр замаар холбогдсоноос гадна өндөр хүчдэлийн шугам, үүрэн телефоны операторууд бүгд холбогдсон, интернет 4G сүлжээтэй холбогдсон байдаг. “Ногоон толгой-1” тоосгоны шаврын орд орших Налайхын хотгорын хэмжээнд сүүлийн жилүүдэд Хятад, Монголын 10 гаруй тоосгоны үйлдвэр ажиллаж байна. Улаанбаатар хотын төвөөс төслийн талбай руу 1 цагийн хугацаанд авто машинаар хүрэх боломжтой.

Зам харилцаа: Налайх дүүрэг нь зам харилцааны хувьд Улаанбаатар хоттой хатуу хучилттай болон төмөр замаар холбогддог. Чиглэлийн автобус, галт тэрэг болон бусад машин техникийн саадгүй үйлчилгээтэй. Тосгоны баруун талаар Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай зам, хойд талаар Улаанбаатар-Хэнтий чиглэлийн мянганы зам дайрч өнгөрдөг. Зүүн аймгуудын автотээврийн гол зам дайран өнгөрдөг тул зүүн аймгуудтай харилцах зам, харилцааны зангилаа болдог.

БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Уурхайн техник, технологийн үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх тоос, шороо болон угаарын хорт хий агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болно.

Шавар олборлох уурхайд:

- ✓ Хөрс хуулах, шавар олборлох үед тоос үүсэх,
- ✓ Тээврийн хэрэгсэл явах үед боссон автозамын тоос,
- ✓ Хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжүүдийн дотоод шаталтын хөдөлгүүрийн ажиллагаанаас гарах утаа болон хорт хий,
- ✓ Уурхайн малталтууд болон овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос,
- ✓ Хөрс болон шаврыг тээвэрлэх үед үүсэх тоос, шороо нь агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болдог.

Үүнээс уурхайн малталтууд болон овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос шороо агаар орчныг байнга бохирдуулдаг бөгөөд салхины хурд, агаарын чийгшил болон хуурайшил зэргээс шалтгаалан жилийн дөрвөн улиралд нөлөөллийн хэмжээ харилцан адилгүй байдаг.

3.2. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Шавар олборлох ажлын байгаль орчинд үзүүлэх экологийн гол үр дагавар нь газрын хурдсыг эвдэж, нүх, карьер үүсэх, улмаар агаарын тоосны бохирдол ихсэх, энэ нь ойр орчимдоо тархах, байгаль хамгаалах шаардлагатай арга хэмжээ авч сөрөг нөлөөллийг бууруулахгүй бол цөлжилт явагдах, цаашид хүрээгээ тэлэхэд хүргэж болзошгүй.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглаж буй шатах тослох материалын хадгалалт, ашиглалтанд байнгын хяналт тавьж болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх шаардлагатай болно.

3.3. УСНЫ ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Уурхайн орчим урсгал ус байхгүй бөгөөд геологи хайгуулын үед шаврын олборлолтын давхаргад гүний ус илрээгүй нилээд гүнд байгаа учир энэ төрлийн нөлөөлөл бага юм.

3.4. ХӨРСНИЙ ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Хүнд машин механизмын хөдөлгөөнөөс хөрс эвдрэх, элэгдэлд орох зэргээр хөрс, ургамлын хүний үйл ажиллагаанд өртөж буй талбайн хязгаар нь түүнээс нилээд хол зайд, наад зах нь 500-1000 м болж, нөлөөллийн хүрээ нь тэлж болохыг цаашид анхаарах шаардлагатай юм.

3.5. УРГАМАЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Төсөл хэрэгжих явцад тухайн орд ашиглах газрын ургамлын бүрхэвч агаар, хөрсний бохирдоос үүдэн ихээхэн хэмжээний доройтолд орсон нь ажиглагдаж байсан.

3.6. Амьтны аймагт нөлөөлөх байдал

Төслийн үйл ажиллагааны улмаас амьтны аймгийн төлөөлөгчдийн идэш тэжээлийн хэлхээ холбоо тасрах, амьдрах нутгийн хүрээ хумигдах, нүүдэллэх талбай хаагдах, техникийн дуу чимээ, доргио чичиргээ, бензин тосны үнэр зэргээс тайван байдал нь алдагдаж, амьдрах орчноосоо дайжих байдлаар тухайн экосистем тодорхой хэмжээгээр өөрчлөгднө.

Сээр нуруугүй амьтад, ялангуяа шавж, аалз хэлбэртэн байгалийн аливаа нэг биоценозод тохиолдох нийт амьтдын биомассын ихэнх буюу 90 хүртэл хувийг бүрдүүлэх бөгөөд тухайн орчинд явагдаж байгаа бодис, энергийн эргэлт, хувирлыг хэвийн явуулах, түргэтгэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Ийм учраас хөрсний амьтдын зонхилох хэсгийн зүйл, тэдгээрийн тоо толгойн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсноор тухайн экосистемийн тогтолцоонд өөрчлөлт хувьсал гарах нь дамжиггүй.

Шатах, тослох материал хадгалах, зөөвөрлөх үед асгах, хатуу хог хаягдлыг ил задгай хаях, эвдэрсэн газрыг хөрсжүүлэх ажил орхигдоход хөрсөнд амьдрагч сээр нуруугүйтэн, жижиг мэрэгчид, тэдгээрээр хооллогч хөхтөн, шувуудын too толгой цөөрөх үйл явц ажиглагдана. Энэ нь амьтан, ургамлын аймгийн төлөөлөгчид харилцан шүтэлцээтэйгээр экосистемийг бүрэлдүүлэх биологийн зүй тогтол юм.

3.7. Төслийн болзошгүй сөрөг нөлөөллийн хэлбэр

*Хүснэгт 10. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр,
үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөлийн төрөлтэй уялдах нь*

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Үрт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтуй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт										
Ургамлын бүтцийн өөрчлөлт	X				X		X			X
Хөрсний элэгдэл, эвдрэл	X				X		X	X		
Геологийн тогтоцын өөрчлөлт	X				X		X	X		
Зэрлэг амьтдын орон зай		X		X			X			X
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт										X
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг	X				X		X		X	
Бэлчээрийн байдал	X				X		X		X	
Эрдэс түүхий эдийн нөөц	X				X		X	X		
Эрчим хүчний нөөц										
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Үндны усны чанар, хэмжээ	X									
Ургал усны хэрэгцээ	X									
Агаарын бохирдол				X					X	
Хөрсний эвдрэл, бохирдол					X		X		X	
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх		X								X
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	X				X		X		X	

Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдхөх	X				X		X		X	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
5. Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдхөх	X				X				X	
Орон нутгийн орлого нэмэгдэх	X				X		X	X		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	X				X				X	
Ажлын байр нэмэгдэх	X									X
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	X				X				X	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		X			X					X
6. Бусад нөлөөлөл										
Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	X				X		X		X	
Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс, ба грунтын усыг бохирдуулах	X						X			X
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж уржих	X				X		X			X
Хүчтэй салхи, уруйн үер	X				X			X	X	
Дүн	19	3	0	9	10	1	14	5	10	8

БҮЛЭГ-4. “НОГООН ТОЛГОЙ-1” ТООСГОНЫ ШАВРЫН УУРХАЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго: “Төгс эрхэс” ХХК-ийн “Ногоон толгой-1” нэртэй тоосгоны шаврын ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго оршино.

“Ногоон толгой-1” нэртэй тоосгоны шаврын ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд **4,450,000** төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт:

Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Үүнд:

- ✓ Агаарын чанар, хөрсөн бүрхэвчид төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох,
- ✓ Байгаль орчныг хамгаалахад хяналт тавих хугацаа, хариуцах эзэнг тогтоох,
- ✓ Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно,
- ✓ БОМТ-ий дагуу үйл ажиллагаа явуулахад дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгүүдийг тодорхойлох,
- ✓ Мэргэжлийн байгаль орчны ажилтантай байх,
- ✓ БОМТ-ий тайлан болон БОМТ-ний хэрэгжилтийг цаг тухай бүрт холбогдох байгууллагуудад хүргүүлэх, тайлагнах, хүлээлгэн өгөх шаардлагатай.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалалтын ажил хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулин дээрх шаардлагын дагуу “Ногоон толгой-1” нэртэй тоосгоны шаврын ордын төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бус нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

4.2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

No	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг (2023 он)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1	- Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох,	Шаврын олборлолтын үед тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх, салхи ихтэй үед тоос багасгах арга хэмжээ авах	Тоосжилт	-	Үйл ажиллагааны зардалд орсон.	Tогтмол			- Агаарын тухай хууль, - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, - Байгаль орчныг хамгаалах. Агаар мандал. Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам MNS 17-2-3-16: 1988,
2	- Агаар бохирдлын улмаас уурхай дахь ажлын нөхцөл, ажилчид болон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх	Хүнд механизмын утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах талаар авах арга хэмжээ	Тээврийн хэрэгсэл	Ш	50'000.0	4	200'000.0	Жилд 1 удаа	- Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007, - Байгаль орчныг хамгаалах. Агаар мандал. Сорыц авахад тавих үндсэн шаардлага MNS 3384: 1982,
3		Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, тэдэнд сургалт, сурталчилгаа явуулах	Ажилчид		Дотоод төлөвлөлтөөр.	Tогтмол			- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990: 2015

4		Тоос шороотой нөхцөлд ажиллаж байгаа ажилчдыг тоосжилтоос хамгаалах зорилгоор өдөрт нормын СҮҮ, цагаан идээ өгөх	Ажилчид	-	Үйл ажиллагааны зардалд орсон.	Тогтмол	
5		Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээ мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Агаарын тоосжилт	-	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан.	Жилд 1 удаа	

Хөрсөн бүрхэвч

1	- Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шим, чийг буурах, бохирдох, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Шимт хөрсний овоолгыг стандартын дагуу хадгалах	Шимт хөрсний овоолго	-	Үйл ажиллагааны зардалд орсон.	Тогтмол	<ul style="list-style-type: none"> - БОХ. Хот суурин газрын хөрсний үнэлгээний үзүүлэлтийн норм MNS 3297- 91 - Шинжилгээнд сорьц авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298- 91 - Хөрс. Сорьц авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS 2305- 94 - Хөрс. Хөрсний агрохимиийн үзүүлэлтийг тодорхойлох MNS 3310- 91 - БОХ. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл MNS 3985- 87 	
2		Шимт хөрсний овоолгыг салхинд хийсэхээс хамгаалж ургамалжуулах	Шимт хөрсний овоолго	-	Дотоод төлөвлөлтөөр.	Үйл ажиллагааны явцад 6,7 сард		
3		Үүрхайд олон салаа зам гаргахгүй байх, таних тэмдэг байршуулах, сайжруулах	Зам талбай		300'000.0	-	300'000.0	Үйл ажиллагааны эхэн үед
4		ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч	Хөрс, гүний ус	-	Дотоод төлөвлөлтөөр.	Тогтмол		

**УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГТ ОРШИХ “Ногоон толгой-1” тоосгоны шаврын уурхайн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-013499**

		алдагдахаас сэргийлэх, хөрс, гүний ус бохирдохоос сэргийлэх, бохирдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авах					- БОХ. Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах шаардлага MNS 17.5.1.19-92
5		Хог хаягдаар уурхайн орчин бохирдохоос сэргийлэх	Уурхайн орчин	-	-	-	Тогтмол
Усан орчин							
1	- Усны нөөц хомсдох, - Үер усны нөлөө үүсэх.	Үер усны аюулаас сэргийлэхийн тулд хамгаалалтын далан байгуулах, үерийн даланг жил бүр сэргээн засварлах	Төслийн үйл ажиллагааны явцад	-	Дотоод төлөвлөлтөөр.	2023 онд	- Усны тухай хууль, - Гадаргын усны чанарыг хянах журам MNS 4047- 88 - Усны анхан шатны тоо бүртгэл хөтлөх журам, - Усны тоо бүртгэлийн тайлан гаргах журам
	-	Нийт дүн		-		500'000.0	

4.3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

“Ногоон толгой-1” шаврын ордыг ашиглах явцад нөхөн сэргээлтийн ажлыг олборлолтонд өртсөн талбайд жил бүр хийх шаардлагатай. Нөхөн сэргээлтийн ажилд тусгай зардал төлөвлөн ажиллах бөгөөд уурхайн ашиглагдсан орон зайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх зайлшгүй шаардлагатай.

“Ногоон толгой-1” шаврын ордын уурхайн орчмын газрын хэвлэй, газрын гадарга, хөрс, гадаргын усан сүлжээ, ургамлан нөмрөгт үүсэх эвдрэлийг техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн арга хэмжээ авч, нөхөн сэргээх ажлын хэмжээ, холбогдох зардлыг төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журам, аргачлал, стандарт шаардлагын дагуу нарийвчлан тооцох зорилготойгоор энэхүү төлөвлөгөөг боловсруулсан болно.

Эвдрэлд орох хөрсний нийт талбай 14.55 га үүнээс жил бүр эвдрэлд орох талбай 3481-4034 м² буюу 0.35-0.4 га орчим байна.

Ашиглалтын энэхүү талбай нь өмнө нь эвдрэлд орж байгаагүй талбай болно. Нөхөн сэргээлтийг жил бүрийн ажлын хэмжээгээр бүрэн гүйцэтгэх боломжтой бөгөөд ашиглалтанд хамаарах талбай нь олборлолтын сүүлчийн жилүүдэд бүрэн нөхөн сэргээгдсэн байна.

Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх нь ашигт малтмалын болон байгаль орчны хуулийн заалтыг хэрэгжүүлэх гол үндэс нь юм.

Хүснэгт 12. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
	1	2	3	4	5	6	7	8	
1.	Техникийн нөхөн сэргээлт								
1.1.	Техникийн нөхөн сэргээлт	Шинээр олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж тусгай овоолгод хадгалах	m ³		Үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардалд орсон.	Жил бүр	- MNS 5916:2008-Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт.		
1.2.		Уурхайн эвдэгдсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	га	0.2	500'000.0	1'000'000.0	2023 онд	- MNS 5917:2008-Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаар эвдэrsэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага.	
2.	Биологийн нөхөн сэргээлт								
2.1.	Биологийн нөхөн сэргээлт	Өмнөх жилүүдэд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд биологийн нөхөн сэргээлт хийх	га	0.2	500'000.0	1'000'000.0	2023 онд	- MNS 5918:2008-Эвдэrsэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага.	
3.	Татан буулгах, хаалтад бэлтгэх								
3.1.	-	Татан буулгах, хаалтанд бэлдэх хугацаа болоогүй.	-	-	-	-	Уурхайн ашиглалтын сүүлийн 5 жилд.	- Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам,	
-	Нийт	-	-	-	-	2'000'000.0	-	-	

4.4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

2023 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд НБОГ-с санал болгосон Баянзүрх дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэр дэх Бага хуандийн аманд нэгдсэн зохион байгуулалтаар мод тарих ажилд оролцоно.

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Дүйцүүлэн хамгаалалт	НБОГ-с санал болгосон газарт	Нэгдсэн зохион байгуулалтаар мод тарих ажилд оролцоно	1	1'000'000.0	1'000'000.0	2023 онд	-
	Нийт	-	-	-	-	1'000'000.0	-	-



Г "НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛ
ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ТИТЭМ ХОЛБОО"
НҮТББ-Д

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР

Нийслэлийн Засаг захирагааны III байр,
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160 0011
Утас: (976-11) 32 37 80, Факс: (976-11) 31 80 03
Цахим шуудан: admin@environment.ub.gov.mn
Цахим хуудас: www.environment.ub.gov.mn

2023.04.12 № 02/766
таний -ны № -т

Г Дүйцүүлэн хамгаалах тухай Г

Нийслэлийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/908 дугаар захирамжийн дагуу “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангулж ажиллахаар нийслэлийн нутаг дэвсгэрт нэгдсэн зохион байгуулалтаар шилмүүст мод тарих ажлыг хийж гүйцэтгүүлэхээр төлөвлөснийг мэдэгдэж байна.


Мод тарих талбайн мэдээллийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 1 хуудастай.



Нийслэлийн байгаль орчны газар ТБАГУТУГ
Удирдлага
Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Рагчaa Энхтайван
2023.04.12 22:16

БАЯНЗУРХ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭР БАГА ХУАНДЫН АМ



ХИЛИЙН ЦЭС

№	N	E
1	47 54 40.2	107 14 52.6
2	47 54 44.8	107 15 17.9
3	47 54 33.4	107 15 25.1
4	47 54 30.1	107 15 19.7
5	47 54 33.5	107 15 07.8
6	47 54 31.0	107 14 57.9



4.5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайн ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх болон ямар нэгэн нүүлгэн шилжүүлэх шаардлагатай зүйлс байхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөх шаардлагагүй болно.

4.6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйлс, археологи, палеонтологийн олдвор тогтоогдоогүй.

Цаашид уурхайн олборлолтын үйл ажиллагааны явцад ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйлс, булш, бунхан, хиргэсүүр зэрэг археологи, палеонтологийн зүйлс илрэх тохиолдолд Соёлын өвийг хамгаалах үүднээс төслийн үйл ажиллагааг түр зогсоож хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад хандаж мэдэгдэл хүргүүлэх шаардлагатай.

4.7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Төгс-Эрхэс” ХХК-ийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсадын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

Хүснэгт 13. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, серөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	-Автомашин, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэрэгээс хээрийн түймэр гарч болзошгүй, -Хүчтэй аадар бороо, аянга цахилгааны улмаас ажлын байрны аюулгүй байдал, цахилгаан тасрах, хүний амь нас, эрүүл мэнд хохирох,	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	Уурхай орчимд	-	200,000	200,000	Тогтмол	-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, -MNS 5390:2004, “ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”
2		Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад байрлуулах, сайжруулах			100,000	100,000		
3	-Ажилчид бертэх, амь нас эрсдэх, шавар олборлолт болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх,	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	-	-	-	Тогтмол	Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”
4		Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусlamжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчидад	-	Үйл ажиллагааны зардалд орсон		Жил бүр	
5	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажиллуулах	Уурхайн ажилчидад	42	Үйл ажиллагааны зардалд орсон		Тогтмол	Тогтмол	Тогтмол
6		Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Уурхайн ажилчидад	42	-	-		

**УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГТ ОРШИХ “Ногоон толгой-1” тоосгоны шаврын уурхайн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-013499**

7	-Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс тээврийн хэрэгслүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж, бэртээх гэх мэт осол аваар гарах.	Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах	Уурхай орчимд	-	Үйл ажиллагааны зардалд орсон	2023 онд	
8		Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоох	Уурхайн удирдлага	-	-	-	2023 онд
9			Уурхай орчимд	-	-	-	Тогтмол
Нийт				300,000	300,000		

4.8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам болон үйлдвэрлэлийн хэрэгцээтэй газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэд аажмаар орох ба задрах хугацаа нь хэтэрхий удаан байдаг учраас байгаль орчинд хамгийн их хор хөнөөлтэй байдаг.

Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хог хаягдлаас үүдэн уурхайн орчин бохирдох.	Зориулалтын хогийн сав байрлуулж, ангилан ялгаж, тэмдэгжүүлэх.	Хог хаягдал	ш	50,000	2	100,000	Тогтмол	-Хог хаягдлын тухай хууль /2017.05.12/, -MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага,
2		Хог хаягдлыг төвлөрсөн нэг цэгт цуглуулж, хогны гэрээ байгуулсны дагуу төвлөрсөн цэгт хогийг тухай бүрт тээвэрлүүлэх		-	200,000	1	200,000	Жилд 1 удаа	
3		Дахин ашиглах, боловсруулах боломжтой хог хаягдлыг цуглуулж, хоёрдогч түүхий эдийн цэгт тушаах		-	-	-	-	Улиралд 1 удаа	
4		Шингэн хог хаягдлыг технологийн дагуу доторлосон зориулалтын нүх цооногт хийж, ойр орчмыг дулааны улиралд ялаа, шавьж үржихээс урьдчилан сэргийлж ариутгал хийж, булж устгах, хог хаягдлын түр ба төвлөрсөн цэгт ариутгал халдвартгүйтгэл зохион байгуулах		-	Дотоод төлөвлөлтөөр			Тогтмол	
5		Уурхайн ойр орчимд хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, Төслийн хэмжээнд бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж хэвших		-	-	-	-	Тогтмол	
		Нийт		-			300,000		

4.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Төгс-Эрхэс” ХХК-ний шаврын орд, тоосгоны үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүрт илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэнэ.

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоо ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож тусгана.

“Төгс-Эрхэс” ХХК нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 15. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаар								
1	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	-Уурхай орчим	Жилд 1 удаа	2 цэг	Агаарын шинжээч- 100,000 Шинжилгээ- 30,000	160,000	Итгэмжлэгдсэн лабораторт агаарын сорьц шинжилгээг шинжилүүлэх	-MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, -MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга -MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга,
2	Агаарын бохирдлын (NO ₂ , SO ₂ , CO) шинжилгээ хийлгэж байх							
Хөрс								

**УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГТ ОРШИХ “Ногоон толгой-1” тоосгоны шаврын уурхайн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-013499**

1	Хөрсний химийн болон физик үндсэн шинж чанар: (Ялзмаг, урвалын орчин, карбонат, нитрат, фосфор, кали, давсжилт, чулуужилт, механик бүрэлдэхүүн, эзлэхүүн жин зэрэг үзүүлэлтүүд)	-Уурхай орчим, -Кемп	Жилд 2 удаа	2 цэг	Хөрсний агрохимийн шинжилгээ- 25,000	50,000	Итгэмжлэгдсэн хөрсний лабораториид шинжлүүлэх.	-MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, -MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох арга -MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага, -MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр.
2	-Хөрсний хүнд металл: кадьми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр.	-Уурхай орчим,	Жилд 2 удаа	1 цэг	Хүнд металлын шинжилгээ 1дээж- 45,000	50,000		
Усан орчин								
1	Усны ерөнхий химийн шинжилгээ: pH, TDS (нийт уссан давс), нийт хатуулаг (CaCO ₃), уссан хүчилтөрөгч, BXX, XXX, Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ -ны агууламж, амт, үнэр, өнгө.	Гүний худгаас	Жилд 2 удаа	Гүний худаг	Усны ерөнхий шинжилгээ 45,000	90,000	Усны итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх	-MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж, -MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага, -MNS 13.060.50 Усны чанарын стандарт -MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл Усны түвшин (газрын гадаргаас ахуйн шаардлага, түүнд тавих хяналт).
Нийт						350,000		

4.10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Төгс-Эрхэс” ХХК-ний шаврын орд болон үйлдвэрийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчинээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна. Байгаль орчны асуудалд зөвхөн байгаль орчны мэргэжилтэн анхаарал хандуулах биш шаврын орд болон үйлдвэрийн бүхий л ажилтнуудын анхаарал хандуулах чухал асуудал юм.

Байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг байгаль орчны мэргэжилтэн хариуцан ажиллах бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Үүнд:

- ✓ Нөхөн сэргээлтийн болон байгаль хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх,
- ✓ Компаний удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагааг удирдаж зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ,
- ✓ Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд нь холбогдох байгууллагуудад хүргүүлж, тайлагнаж байх,
- ✓ Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл (газар хөдлөлт, үер, салхи, шуурга) болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллагсдыг жилд 1 удаа сургаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, энэ талаар дотоод журам төлөвлөгөөтэй ажиллана,
- ✓ Ахуйн хог хаягдлыг байнга цэвэрлэн ариутгаж байх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж байх.

Хүснэгт 17. Тухайн жилийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон Төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар		
			2023 онд						
			4-6-р сар	7-9-р сар	10-11-р сар				
1	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжлийн хүн ажиллуулах	Дотоод төлөвлөлтөөр	+	+	+	“Төгс эрхэс ХХК	Байгаль орчны мэргэжлийн ажилтан уурхайд байх шаардлагатай.		
2	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулах	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	+			Уурхайн удирдлага	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааврыг чанд мөрдөн ажиллах шаардлагатай.		
3	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Тогтмол			Уурхайн удирдлага	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах шаардлагатай.		
4	Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		+		Уурхайн удирдлага	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж байх шаардлагатай.		
5	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээний дагуу хамтран ажиллах	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	+	+	+	“Төгс эрхэс” ХХК	Орон нутагтай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтарч ажиллах.		
Нийт		-							

4.11. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Төгс-Эрхэс” ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 18. Олон нийтэд төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд		Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зохион байгуулах газар
Нийслэлийн байгаль орчны газар, БОАЖЯ	Хорооны ИНХ	Хуралд танилцуулах	БОМТ-ийн 2023 оны хэрэгжилтийн тайлан	11-р сарын 01-ний өдрийн дотор	Хорооны төв
	Дүүргийн ЗД, БОХХБайцаагч	Уулзалт			Дүүргийн төв
Төрийн захиргааны төв байгууллага	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Тайлан, төлөвлөгөөг тайлан хэлбэрээр болон Файл хэлбэрээр	2024 оны БОМТ	12-р сарын 01-ний өдрийн дотор	УБ хот

4.12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН НЭГТГЭЛ

“Төгс-Эрхэс” ХХК-ийн 2023 оны БОМТ-г БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа. 2023 онд БОМТ-нд нийт 4,450,000 төгрөг зарцуулахаар төлөвлөлөө

Хүснэгт 19. Төслийн 2023 оны БОМТ-ний зардлын нэгтгэл

№	Арга хэмжээ	Зардал' төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	500'000.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	2'000'000.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1'000'000.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	300'000.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	300'000.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	350'000.0
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
10	Олон нийтэд тайлагнах төлөвлөгөө	-
Нийт дүн		4'450'000.0

ДҮГНЭЛТ

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Төгс-Эрхэс” ХХК-ний “Ногоон толгой-1” тоосгоны шаврын уурхайн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг БОАЖ-ын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Шавар олборлолт, тоосго үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах явцад нөлөөлөлд голчлон өртөгч нь хөрс, ургамал, агаар, газрын ба геологийн тогтоц юм.

Иймд сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх ажлыг жил бүрийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заагдсан арга хэмжээг цаг тухайд нь гүйцэтгэж, үр дүнд нь дүгнэлт хийн ажиллах шаардлагатай.

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийтдээ 4'450'000.0 (Дөрвөн сая дөрвөн зуун тавин мянган төгрөг) төгрөг зарцуулахаар гарсан байна.

“Төгс-Эрхэс” ХХК нь 2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хуулийн 31-р зүйлд заасны дагуу БОМТ-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал дахь нөхөн сэргээлтийн зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх үүрэгтэй. 2023 оны Нөхөн сэргээлтийн нийт зардлын 50% буюу 1'000'000 төгрөг (**Нэг сая төгрөг**) төгрөгийг БОАЖЯ-ы тусгай дансанд байршуулна.

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьялагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг аймаг, нийслэлийн томилсон ажлын хэсэг газар дээр нь хянаж үнэлсэн нэгдсэн дүн 90 онооноос дээш гүйцэтгэлтэй байвал төсөл хэрэгжүүлэгчээс боловсруулж ирүүлсэн дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан батлах нэг нөхцөл болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Ногоон толгой-1” тоосгоны шаврын ордод 2012-2013 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, УБ-2013 он
2. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Ногоон толгой-1” тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглах Техник-Эдийн засгийн үндэслэл, УБ-2017 он
3. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Ногоон толгой-1” тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, УБ-2018 он
4. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Ногоон толгой-1” тоосгоны шаврын уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, УБ-2022 он
5. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Ногоон толгой-1” тоосгоны шаврын уурхайн 2023 оны Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, УБ-2023 он
6. Байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах” журам
7. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем - www.legalinfo.mn
8. Байгаль орчны мэдээллийн сан - www.eic.mn